

Бага эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил-2

Сорилын зөв хариулт

1-C, 2-A, 3-C, 4-D, 5-D, 6-B, 7-A, 8-C, 9-C, 10-D, 11-E, 12-E, 13-E, 14-D, 15-B, 16-A, 17-A, 18-D, 19-B, 20-B, 21-A, 22-B, 23-A, 24-C, 25-A, 26-A, 27-D, 28-D, 29-D, 30-D, 31-C, 32-B, 33-A, 34-A, 35-B, 36-D, 37-B, 38-C, 39-A, 40-D, 41-D, 42-A, 43-A, 44-C, 45-A, 46-D, 47-A, 48-D, 49-D, 50-D, 51-E, 52-A, 53-B, 54-A, 55-A, 56-B, 57-B, 58-A, 59-D, 60-A, 61-B, 62-D, 63-D, 64-D, 65-E, 66-A, 67-B, 68-E, 69-C, 70-A, 71-D, 72-D, 73-A, 74-E, 75-C, 76-A, 77-B, 78-C, 79-A, 80-D, 81-B, 82-B, 83-B, 84-D, 85-D, 86-A, 87-C, 88-C, 89-B, 90-E, 91-D, 92-B, 93-D, 94-E, 95-A, 96-E, 97-A, 98-B, 99-A, 100-A, 101-D, 102-C, 103-E, 104-D, 105-D, 106-B, 107-E, 108-A, 109-D, 110-E, 111-A, 112-A, 113-C, 114-A, 115-C, 116-D, 117-D, 118-D, 119-C, 120-D, 121-A, 122-C, 123-A, 124-D, 125-B, 126-B, 127-B, 128-A, 129-D, 130-D, 131-B, 132-A, 133-B, 134-A, 135-D, 136-E, 137-C, 138-D, 139-B, 140-B, 141-A, 142-C, 143-A, 144-B, 145-A, 146-C, 147-C, 148-C, 149-B, 150-C, 151-A, 152-D, 153-D, 154-B, 155-E, 156-D, 157-C, 158-E, 159-C, 160-B, 161-E, 162-A, 163-E, 164-E, 165-A, 166-A, 167-A, 168-A, 169-A, 170-C, 171-A, 172-B, 173-A, 174-E, 175-A, 176-E, 177-D, 178-E, 179-E, 180-A, 181-A, 182-A, 183-A, 184-E, 185-A, 186-B, 187-E, 188-E, 189-E, 190-C, 191-A, 192-A, 193-B, 194-B, 195-E, 196-A, 197-B, 198-D, 199-D, 200-C,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (Е.)

/1./ Уураг дутагдлын хаван ямар өвчтөнд илүүтэй тохиолдох вэ?

- А. Зүрхний дутагдалтай
- В. Харшилтай
- С. Хүнд тураалтай
- Д. Амьсгалын дутагдалтай
- Е. Амьсгалын замын халдвартай

/2./ Венийн судсанд тарилга хийх үед асептик зарчим алдагдвал доорхи хүндрэлүүдээс аль нь тохиолдох вэ?

- А. Сепсис
- В. Абсцесс
- С. Шок
- Д. Эмболи

Е. Тромбо

/3./ Зүрхний цочмог шигдээсийн үеийн өвдөлтийн үргэлжлэх хугацааг тодорхойлно уу?

- A. 5 -10 минут
- B. 10-15 минут
- C. 20 мин дээш
- D. 1-2 минут
- E. 3-5 минут

/4./ Титэм судас тэлэх үйлчилгээтэй эм аль нь вэ?

- A. Нифедипин
- B. Атеголол
- C. Пропроналол
- D. Нитроглицерин
- E. Аспирин

/5./ Ихэс түрүүлсэн үед ямар шинжилгээ яаралтай хийж оношийг батлах вэ?

- A. Үтрээний үзлэг
- B. Рентген шинжилгээ
- C. Цистографи
- D. Чанд авиан шинжилгээ
- E. Маммографи

/6./ 8 сартай хүүхэд халуурсан, татсан зовиуртай үзүүлэхэд хүүхдийн халуун 38 хэм, таталт намдсан боловч маш их шаналгаатай, чихнээс булаг гойжоод сар болж байгаа. Үзлэгээр чихний ард хүндүүр хавагнасан улайлт байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- A. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний архаг халдвар
- B. Маш хүнд халууралт өвчин. Хөхлөг ургацын үрэвсэл
- C. Халууралт. Чихний архаг халдвар
- D. Халууралт. Чихний цочмог халдвар
- E. Чихний цочмог халдвар

/7./ Цусанд ямар бодис ихэссэнээс арьс салст шарладаг вэ?

- A. Билирубин
- B. Холестрин
- C. Амилаза
- D. Уураг
- E. Сахар

/8./ Сувилгааны үйл ажиллагааны “Үнэлгээний” шатлалын үед сувилагч юу хийх ёстой вэ?

- A. Шийдвэрлэсэн асуудалд үнэлгээ өгөх
- B. Тавьсан сувилгааны оношид үнэлгээ өгөх
- C. Өвчтөн үзэж үнэлгээ өгөх
- D. Сувилгааны төлөвлөгөөний боловсруулалтанд үнэлгээ өгөх
- E. Дурдсан үйл ажиллагаа бүгд хамаарна

/9./ Эмэгтэйчүүдийн ямар өвчнийг арын хүнхрээгээр хатгалт хийж оношлох вэ?

- A. Умайн хүзүүний шархлаа
- B. Умайн хоргүй хавдар
- C. Умайн гадуурхи жирэмслэлт
- D. Даавруудын цочмог үрэвсэл
- E. Үргүйдэл

/10./ Жирэмсний гарцаагүй шинж тэмдэг.

- A. Биений юм хоригдох

- В. Үтрээ болон умайн хүзүүний салст хөхрөх
- С. Хэвлийн цагаан шугам, хөхний толгой нөсөөтөх
- Д. Ургийн хэсэг тэмтрэгдэх
- Е. Огиулж бөөлжих.

/11./ Ходоодны шархлаа гэж сэжиглэсэн үед хийх шинжилгээг нэрлэнэ үү?

- А. Ходоодны шүүсийг шинжлэх
- В. Цусны ийлдэст гастрины түвшинг тодорхойлох
- С. Цэсний хүүдийн зураг авах
- Д. Хэвлийн тойм рентген зураг авах
- Е. Ходоод дурандах

/12./ Зайлах бургуй тавих үед өвчтөний байрлал ямар байвал илүү тохиромжтой вэ?

- А. Босоо
- В. Хэвтээ
- С. Баруун хажуугаар нь
- Д. Зүүн хажуугаар нь
- Е. Өвдөг тохойн байрлал

/13./ Трансляци гэж юу вэ?

- А. ДНХ-ээс уураг үүснэ
- В. ДНХ-ээс мРНХ үүснэ
- С. мРНХ-ээс ДНХ үүснэ
- Д. ГФА үүснэ
- Е. мРНХ-ээс уураг үүснэ

/14./ 3 настай цусан суулгалттай хүүхдэд котримоксазолын 480 мг шахмалаас яаж уулгах вэ?

- А. 1 шахмалаар хоногт 4 удаа уулгана
- В. Тал шахмалаар хоногт 4 удаа уулгана
- С. Тал шахмалаар хоногт 3 удаа суулгалт намдтал уулга
- Д. 1 шахмалаар хоногт 2 удаа 5 хоногийн турш уулгана
- Е. 2 шахмалаар хоногт 1 удаа суулгалт намдтал уулгана

/15./ Өөх тосны солилцооны өөрчлөлтийг засах эмчилгээнд аль орох вэ?

- А. Антиагрегант эм: аспирин
- В. Статины бүлгийн эм: симбастатин
- С. Антиоксидант: вит Е
- Д. АХФС: эналаприл
- Е. Нянгийн халдварын эсрэг эм: антибиотик

/16./ 1-ээс дээш насны хүүхдэд нэмэгдэл хоолыг нэг удаа хэдий хэмжээтэй өгөх вэ?

- А. 1 1/4-1 1/2 аяга буюу 250-300 мл
- В. 1 аяга буюу 200 мл
- С. 50 мл-ээр ойр ойрхон
- Д. 100 мл-ээр ойр ойрхон
- Е. Хүссэн хэмжээгээр

/17./ 38.5 хэмээс дээш халуурч буй 1 нас 5 сартай хүүхдэд парацетамолын 500 мг шахмалыг яаж уулгах вэ?

- А. 1\4-ээр
- В. 1\2-ээр
- С. 1,5-аар
- Д. 1 ш-ээр
- Е. 2ш-ээр

/18./ Ходоодны шүүсийг шинжлэхэд алийг нь хэрэглэдэг вэ?

- A. Секретин
- B. Холецистокинин
- C. Атропин
- D. Пентгастрин
- E. Магни сульфат

/19./ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын /ДЭМБ/ ЗСӨ-ний эрсдлийн түвшинг тодорхойлох хүснэгтийг ашиглахдаа аль үзүүлэлтээс бусдыг ашигладаг вэ?

- A. нас
- B. диастолын даралт
- C. тамхи татдаг эсэх
- D. холестерин
- E. хүйс

/20./ Ранитидин ямар эмийн бүлэгт хамаарагдах вэ?

- A. Шүүрэл саармагжуулах
- B. Гистамины H-2 рецепторыг саатуулагч
- C. Ходоодны хөдөлгөөнийг зохицуулагч
- D. Булчин сулруулагч
- E. Салстыг нөхөн төлжүүлэгч

/21./ Хяхтнаа амьсгал юугаар ялгагдах вэ?

- A. Амьсгал авахад шуугиантай, зовиуртай
- B. Амьсгал гаргахад шуугиантай, зовиуртай
- C. Амьсгал авах, гаргах нь шуугиантай, зовиуртай
- D. Амьсгал гаргахад хожигноо сонсогдоно
- E. Уушги чагнахад гуурсан хоолойн амьсгал сонсогдоно

/22./ Сампингийн эрхийн шинжийг хаана тэмтэрч үзэх вэ?

- A. Өвчүүний эрмэгээр
- B. Хавирганы ясан ба мөгөөрсөн хэсгийн уулзвар дээр
- C. Суганы дунд шугамаар
- D. Суганы арын шугамаар
- E. Өвчүүн дээр

/23./ Каццоны сорилоор ямар өвчин тээгчийг илрүүлэх вэ?

- A. Бэтэг
- B. Бруцеллёз
- C. Сүрьеэ
- D. Халдварт саа
- E. Ревматизм

/24./ Гүйлсэн булчирхайн үүргүүдийг нэрлэнэ үү?

- A. Хамгаалах, мэдээлэх, залгих
- B. Хамгаалах, сэргээх, залгих
- C. Мэдээлэх, хамгаалах, дархлалын
- D. Чийглэх, залгих, хамгаалах
- E. Амьсгалах, хамгаалах, залгих

/25./ Гүйлсэн булчирхайн архаг үрэвслийг цаг тухайд нь эмчлүүлээгүйгээс хүүхдэд ямар өвчнүүд үүсч болох вэ?

- A. Хэрэх өвчин, үе мөч, бөөр зүрх судас, бамбай булчирхай, ходоодны архаг үрэвсэл, цус багадалт, судасны цусархаг үрэвсэл, бэлгийн үйл ажиллагааны хямрал
- B. Гахайн хавдар, тунгалгийн зангилаанууд томрох
- C. Шүд хорхойтох, чихрийн шижин

D. Зүрх томрох, цус багадалт

E. Бөөр өвдөнө

/26./ 6 сартай хүүхэд өчигдөрөөс халуурсан, тайван биш болсон зовиуртай, үзүүлэхэд чихнээс булаг гарч байв. Эх нь хүүхдийн чихнээс урд өмнө булаг гарч байсныг анзаараагүй тул хэд хоног гарч байгааг мэдэхгүй. Өөр шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

A. Халууралт. Чихний цочмог халдвар

B. Халууралт. Чихний архаг халдвар

C. Хөхлөг ургацын үрэвсэл

D. Маш хүнд халууралт өвчин

E. Чихний архаг халдвар

/27./ Элэгний архаг хэлбэрийн үрэвслийн үед аль шинж нь түгээмэл илрэх вэ?

A. Элэгний үйл ажиллагааны дутагдал

B. Өвдөлтийн хам шинж

C. Боловсруулалтын хямралын хам шинж

D. Мэдрэл сульдлын хам шинж

E. Цусархаг хам шинж

/28./ Сар гаруй суулгасан атлаа хоол, ундандаа сайн, орчиндоо хэвийн харьцаатай, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хэвийн арилж буй 2 настай хүүхдийг хэрхэн ангилах вэ?

A. Ужиг суулгалт

B. Шингэн их алдалттай суулгалт.

C. Шингэн алдалттай суулгалт.

D. Шингэн алдалтгүй, ужиг суулгалт

E. Шингэн алдалттай, хүнд ужиг, цусан суулгалт

/29./ 3 сартай зөвхөн хөхөө хөхдөг “Шингэн алдалтгүй суулгалттай” хүүхдэд ямар шингэн уулгахыг зөвлөх вэ?

A. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа шингэлсэн шөл уулгах

B. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа будааны шүүс уулгах.

C. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа тараг, хярам уулгах

D. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа буцалсан ус, ШСДУ уулгах

E. Зөвхөн ШСДУ уулгах

/30./ Цөсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан юу вэ?

A. Удамшил

B. Сэтгэл санааны цочрол

C. Цаг уурын өөрчлөлт

D. Халдвар

E. Витамины дутагдал

/31./ В вирүсийн гадаргуугийн антиген аль вэ?

A. HBcAg

B. HBeAg

C. HbsAg

D. Anti-HBs

E. Anti-HCV

/32./ Цөсний хүүдийн цочмог үрэвслийн үед цусны ерөнхий шинжилгээнд гарах өөрчлөлт юу вэ?

A. Гемоглобин ихсэх

B. Цагаан эс олшрох

C. Цусанд сахар багасах

D. Цусанд сахар ихсэх

Е. Эритроцитын хэмжээ ихсэх

/33./ Нянгаар үүсгэгдсэн цочмог бронхитын үед ямар эмчилгээ хийх вэ?

А. Антибиотик, сульфаниламид

В. Халуун бууруулах

С. Цэр шингэлэх, цэр ховхлох

Д. Гуурсан хоолой өргөсгөх

Е. Судас өргөсгөх

/34./ Цусанд ямар бодис ихэссэнээс арьс салст шарладаг вэ?

А. Билирубин

В. Холестрин

С. Амилаза

Д. Уураг

Е. Сахар

/35./ Ихэс түрүүлэх үеийн үндсэн шинж тэмдэг юугаар илрэх вэ?

А. Өвдөх

В. Цус алдах

С. Ургийн ус эрт гарах

Д. Ургийн зүрхний цохилт хурдсах

Е. Хавагнах

/36./ Ургийн буруу байрлал ямар эмгэгийн үед илүүтэй тохиолдох вэ?

А. Тулгар жирэмсэн

В. Жирэмсний хордлого

С. Төрөх хүчний сулрал

Д. Ихэс түрүүлэлт

Е. Төрөх үеийн цус алдалт

/37./ Зүрхний байрлалыг зөв тодорхойлно уу?

А. Цээжний хөндийн голд байрлана

В. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас зүүн тийш $2/3$ -д байрлана

С. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас баруун тийш $2/3$ -д байрлана

Д. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас зүүн тийш $1/3$ -д байрлана

Е. Цээжний хөндийд биеийн гол шугамнаас баруун тийш $1/3$ -д байрлана

/38./ Амьдралын хэв маяг өөрчлөх зөвлөгөөг Артерийн даралт /АД/ ихтэй аль хүмүүст өгөх вэ?

А. АД-ын түвшингийн ангилалаар гуравдугаар зэрэгтэй бол

В. АД бууруулах эм уудаг бол

С. АД бууруулах эмэн эмчилгээ хийлгэдэг эсэхээс үл хамааран бүх өвчтөнд

Д. АГ эхэлж байгаа хүнд

Е. АД хэвийн дээд түвшинд байгаа бол

/39./ Хэсэг газрын нянгийн халдвартай 3,6 кг жинтэй нярайд амоксациллины 250 мг шахмалаас ямар тунгаар , яаж өгөх вэ?

А. $1/4$ шахмалаар хоногт 3 удаа 5 хоног

В. Тал шахмалаар хоногт 3 удаа 5 хоног

С. $1/4$ шахмалаар хоногт 4 удаа 5 хоног

Д. Тал шахмалаар хоногт 4 удаа 5 хоног

Е. Нэг шахмалаар хоногт 4 удаа 5 хоног

/40./ Эмнэлгээс гадуур үүсэх уушгины үрэвслийн гол үүсгэгчийг нэрлэнэ үү?

А. Цитомигало вирус

В. Мөөгөнцөр

- С. Микобактер
- Д. Пневмококк
- Е. Сүрьеэгийн савханцар

/41./ Ревматойдный артритийн үед хэрэглэхгүй эмчилгээг сонгоно уу?

- А. Кортикостеройдоор эмчилнэ
- В. Индометацин, метиндол
- С. Алтны бэлдмэл
- Д. Зүрхний гликозид
- Е. Полиартиритийн үед үений хөндийд гидрокортизон тарина

/42./ Элэг цэсийг хэт авиан шинжилгээгээр шинжлэхэд өвчтөнд ямар бэлтгэл хийх вэ?

- А. Өлөн байлгах
- В. Цэвэрлэх бургуй тавих
- С. Давсаг шээстэй байх
- Д. Ходоод угаах
- Е. Урьд оройноос хоол сойх

/43./ Хүнд тураалтай хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?

- А. А аминдэм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- В. Хооллолтын байдлыг үнэлэн хоолны зөвлөгөө өгнө.
- С. Фермент эмчилгээ хийж гэрт нь эмчилнэ
- Д. Дексаметазон уулгана.
- Е. Аминдэмээр гэрт нь эмчилнэ

/44./ Ходоод нь өвдөж буй өвчтөнд хийгдэх сувилгааг сонгоно уу?

- А. Хүйтэн жин тавина.
- В. Халуун жин тавина
- С. Хоол сойно.
- Д. Эмчийн заалтаар эмчилгээ хийх
- Е. Цэвэрлэх бургуй тавина.

/45./ Боомын нууц үе аль нь вэ?

- А. 2-3 хоног
- В. 10-15 хоног
- С. 9-15 хоног
- Д. 4-5 хоног
- Е. 1-2 сар

/46./ Өндөр халууралтанд хэдэн хэм орох вэ?

- А. 37,5-38
- В. 38-38,5
- С. 38,5-39,5
- Д. 39,5-41
- Е. 41 дээш

/47./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна. Түүний чихэнд хүрэхэд маш их эмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Хэрхэн ангилах вэ?

- А. Чихний цочмог халдвар
- В. Хөхлөг ургацын үрэвсэл
- С. Чихний архаг халдвар
- Д. Аюултай ерөнхий шинжтэй
- Е. Маш хүнд өвчин

/48./ Хэрлэг төст үений үрэвслийн онцлог шинж юу вэ?

- A. Эмгэг голчлон том үеийг хамарч хэрж өвдөнө
 - B. Хөлийн хурууны үений хурц үрэвсэл
 - C. Нурууны үе гэмтэж явж чадахгүй болно
 - D. 2 талд тэгш хэмтэй, жижиг үенээс эхэлж гэмтэнэ
 - E. Өвдөгний үе хавдаж, шөнөдөө маш хүчтэй өвдөнө
- /49./ Нугасны шингэн хаана агуулагддаг вэ?
- A. Хатуу бүрхүүл, ясны эд хоёрын хооронд
 - B. Хатуу бүрхүүл, судсан бүрхүүл хоёрын хооронд
 - C. Нугасны дотор талаар
 - D. Нугасны гадна талаар
 - E. Нугасны гадна ба дотор талаар
- /50./ Сар гаруй суулгасан, өчигдрөөс баасанд нь цус харагдсан, нүд нь хонхойсон, шингэн ховдоглон ууж буй, арьсны хуниас хэвийн арилж буй, ууртай, цочромтгой болсон 1 настай хүүхдэд ямар ангилал тавих вэ?
- A. Ужиг суулгалт
 - B. Шингэн их алдалттай суулгалт
 - C. Шингэн алдалтгүй суулгалт
 - D. Шингэн алдалттай, хүнд ужиг, цусан суулгалт
 - E. Дисбактериоз.
- /51./ “Шингэн алдалттай суулгалт” гэж ангилагдсан хүүхдэд 4 цагийн турш ямар хэмжээний шингэн уулгах вэ?
- A. 50мл
 - B. 100мл
 - C. 200 мл
 - D. 400 мл
 - E. Хүүхдийн биеийн жинг 75 мл-т үржүүлээд гарах хэмжээгээр шингэнийг уулгана.
- /52./ Уушгины үрэвсэлд халдварын эсрэг ямар эмийг сонгох вэ?
- A. Антибиотек
 - B. Антиоксидант
 - C. Антигистамин
 - D. Хордлогын эсрэг эмчилгээ
 - E. Дархлаа дэмжих эмчилгээ
- /53./ Цустай суулгасан нярайг хаана, хэн эмчлэх вэ?
- A. Гэрт нь өрхийн эмч эмчилнэ
 - B. Эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ
 - C. Амбулатороор эмчилнэ
 - D. Амбулатороор шинжилгээ өгч, шаардлагтай бол эмнэлэгт хэвтүүлнэ.
 - E. Гэрт нь ээж нь эмчилнэ
- /54./ Бөмбөрийн цохиур, цагны шилний шинж ямар эмгэгийн үед илрэх вэ?
- A. Гуурсан хоолой тэлэгдэх эмгэг
 - B. Гуурсан хоолойн хурц үрэвсэл
 - C. Уушигны хурц үрэвсэл
 - D. Уушигны сүрьеэ
 - E. Гуурсан хоолойн багтраа
- /55./ Гуурсан хоолойн архаг үрэвслийн үед дараах шинжүүдээс аль нь илрэх вэ?
- A. Байнга ханиалгах
 - B. Цээжээр өвдөх
 - C. Цустай ханиах

- D. Амьсгаадах
- E. Маш их цэртэй ханиах

/56./ Хэрлэг төст үений үрэвсэлийн /Ревматоид артрит/ оношлогооны шалгуурт аль шинж ордог вэ?

- A. Том үенүүд өвдөх
- B. Өглөөний хөшингө 1 цагаас илүү
- C. Халуурах
- D. Хорей
- E. Халдварын анамнезтай байх

/57./ Тархмал хордлогот бахуугийн үед алийг нь сонгох вэ?

- A. Халуун усанд оруулна
- B. Бүдэг гэрэлтэй өрөөг сонгоно
- C. Хуурай халуун усанд оруулна
- D. Гичтэй усанд оруулна
- E. Хүйтэн усанд оруулна

/58./ Чихнээс булаг гарч буй хүүхдийн чихийг чихээсээр хэрхэн цэвэрлэх вэ?

- A. Хоногт 3-аас доошгүй удаа чихийг чихээсээр хуурайштал цэвэрлэнэ. Чих хуурайштал эмчилгээг үргэлжлүүлнэ
- B. Өглөө чихээс хийж орхиод орой чихээсийг шинээр солино.
- C. Хоногт нэг удаа өрхийн эмчээр чихээс хийлгэж байна
- D. Хоногт нэг удаа ээж нь чихээс хийнэ
- E. Хоногт нэг удаа чихээсийг 5 хоногийн турш хийнэ.

/59./ Гүйлсэн булчирхайн цочмог үрэвсэл халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

- A. Биеэр түгээмэл улаан тууралт шатлаж гарна
- B. Цустай суулгана
- C. Дагзны булчин хөшингө шинж илэрнэ
- D. Гүйлсэн булчирхай улайж, хөөнгөтөж, идээлсэн байна
- E. Ханиах, нус гойжих шинж илэрнэ

/60./ Гахай хавдар өвчний үед эрүүний ар хонхор, чихний омогны урд, гавлын хөхлөг ясны орой орчим дарахад эмзэгшилтэй байх нь хэний шинж вэ?

- A. Филатовийн
- B. Пастийн
- C. Мурсугийн
- D. Мурсугийн
- E. Падалк

/61./ Насанд хүрсэн хүний биеийн жингийн хэдэн хувийг цус эзлэх вэ?

- A. 1-10 хувь
- B. 5-8 хувь
- C. 15-20 хувь
- D. 10-15 хувь
- E. 4 - 5%

/62./ Архаг гепатитын үед аль шинж түгээмэл илрэх вэ?

- A. Элэгний үйл ажиллагааны дутагдал
- B. Өвдөлтийн хам шинж
- C. Боловсруулалтын хямралын хам шинж
- D. Мэдрэл сульдлын хам шинж
- E. Цусархаг хам шинж

/63./ Улаанбурхэнтай 4 настай хүүхдэд А аминдэмийн 100000 нэгжтэй, хөх капсулыг яаж өгөх вэ?

- A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг.
- B. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь өг
- C. 1 капсулыг яаралтай өг
- D. 2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 2 капсулыг эхэд нь өг.
- E. 3 капсулыг яаралтай өг

/64./ Бамбай булчирхайн бүтцийн өөрчлөлтийг илрүүлэх гол шинжилгээг нэрлэнэ үү?

- A. Бамбай булчирхайд цацраг идэвхит иодын шингээлт үзэх
- B. Термографи
- C. Бамбай булчирхайн зураг авах
- D. ЭХО
- E. Цусан бамбайн даавруудыг тодорхойлох

/65./ Халдварын гаралтай эндокардитийн үед ямар шинж өвөрмөц биш вэ?

- A. Дэлүү томрох
- B. Протейнурия цусархаг тууралт
- C. Лейкопения
- D. СОЭ хурдсах
- E. Зүрхний өвдөлт хэдэн сек-с 15 мин үргэлжилнэ

/66./ 4 настай хүүхэд 4 хоног, өдөрт 5 удаа шингэн суулгасан, баасанд цус байхгүй, орчиндоо хэвийн харьцаатай, хоол ундандаа сайн, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хэвийн арилж байна. ХӨЦМ-ийн дагуу хэрхэн ангилах вэ?

- A. Шингэн алдалтгүй суулгалт
- B. Шингэн алдалттай суулгалт
- C. Шингэн их алдалттай суулгалт
- D. Шингэн алдалтгүй ужиг суулгалт
- E. Шингэн алдалттай ужиг суулгалт

/67./ 3 настай “Шингэн алдалтгүй суулгалттай” хүүхдэд суулгалт бүрийн дараа ямар хэмжээний шингэн уулгах вэ?

- A. 50-100 мл
- B. 100-200 мл
- C. 500-600 мл
- D. 1000 мл
- E. 1500 мл

/68./ Ходоод гэдэсний шархлаа гэж сэжиглэгдсэн үед хийх шинжилгээг нэрлэнэ үү?

- A. Ходоодны шүүсийг шинжлэх
- B. Цусны ийлдэст гастрины түвшинг тодорхойлох
- C. Цөсний хүүдийн зураг авах
- D. Хэвлийг рентгенээр харах
- E. Ходоод гэдэсийг дурандах

/69./ Халдварт эндокардитийн риск факторт хамаарахгүй 1 зүйлийг сонгоно уу?

- A. Цистоскопия
- B. Вен сэтгүүрдэх
- C. А|Д ихсэх
- D. Умай цэвэрлэх
- E. Зүрхний төрөлхийн гажиг

/70./ АД-ын түвшингийн ангилалаар систолын гипертензид аль нь орох вэ? (мм муб)

- A. 160/80

- B. 160/90
- C. 140/90
- D. 140/100
- E. 180/90

/71./ Зүрхний үнхэлцгэнд шингэн хуримтлагдсанаас амьсгаадаж, айдас түгшүүртэй байгаа өвчтөнд ямар эмчилгээ хамгийн чухал вэ?

- A. Эуфиллин
- B. Антибиотик
- C. Сальбутамол
- D. Хатгалт хийж үнхэлцгэнд буй шингэнийг соруулж авах
- E. Панангин

/72./ Трихомонадын гаралтай үтрээний үрэвслийн үед доорх эмийг хэрэглэхгүй:

- A. Трихопол
- B. Метронидазол
- C. Метрогел
- D. Клотримазол
- E. Клион

/73./ Эмэгтэйн шээсний сүвийн уртын хэмжээг олно уу?

- A. 4 см
- B. 6 см
- C. 8 см
- D. 10см
- E. 3 см

/74./ Атеросклероз аль судсыг хамардаг өвчин бэ?

- A. Вений судасны өвчин
- B. Капилляр судасны өвчин
- C. Аортын үрэвсэлт өвчин
- D. Зүрхний судасны өвчин
- E. Артерийн судасны үрэвсэлт өвчин

/75./ Жирэмсний аль үеийн ходлого жирэмсний амь насанд илүү аюултай вэ?

- A. Жирэмслэлт бол физиологийн процесс тул амь насанд аюулгүй
- B. Жирэмсний эрт үеийн хордлого
- C. Жирэмсний хожуу үеийн хордлого
- D. Жирэмсний эрт үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
- E. Жирэмсний хожуу үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.

/76./ Зүрхний шигдээсийн үед хамгийн элбэг тохиолддог хүндрэл аль нь вэ?

- A. Зүрхний гаралтай шок
- B. Уушигны хаван
- C. Артерийн даралт ихсэх
- D. Зүрх цусаар чихэлдэх
- E. Тосгуур ховдлын бүрэн хориг үүсэх

/77./ Леопольдийн 2-р аргаар юуг тодорхойлох вэ?

- A. Умайн ёроолын өндрийн түвшин
- B. Ургийн байрлал, хэлбийлт
- C. Түрүүлсэн хэсэг
- D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
- E. Ургийн жин

/78./ Үрэвслийн шинж давамгайлсан гастрит аль нь вэ?

- A. Эмийн шалтгаант гастрит
 - B. Цэсний сөөргөө урсгалын шалтгаант
 - C. Хеликобактераар үүсгэгдсэн гастрит
 - D. Архи, тамхины
 - E. Өрцний ивэрхийн шалтгаантай гастрит
- /79./ Чихнээс булаг гарч буй 2 сар хүрээгүй нярайд ямар арга хэмжээ авах вэ?
- A. Үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг булчинд тариад, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 - B. Үүсгэгчийн эсрэг эм уулган, чихийг чихээсээр цэвэрлэн гэрээр эмчилнэ.
 - C. Чихэнд ус төрөгчийн хэт исэл дусаан, антибиотиктой уусмалаар угаана
 - D. Гидрокортизонтой чихээс чихэнд хийж орхино
 - E. Чихийг хөхний сүүгээр угаахыг зөвлөнө
- /80./ В гепатитын нууц үе дунджаар хэд хоног үргэлжилдаг вэ?
- A. 10-15 хоног
 - B. 10-45 хоног
 - C. 45-90 хоног
 - D. 50-180 хоног
 - E. 2-4 долоо хоног
- /81./ Атеросклерозын үүсэл хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү
- A. Амьтны гаралтай өөх тос их хэрэглэх
 - B. Давс их хэрэглэх
 - C. Эрс тэс уур амьсгал
 - D. Байгаль газар зүйн онцлог
 - E. Бодисын солилцоо удаан явагдах
- /82./ Насанд хүрсэн хүний артерийн даралтын хамгийн тохиромжтой хэмжээг заана уу?
- A. 120/80
 - B. 120/ 80-аас бага
 - C. 140/90-ээс бага
 - D. 135/85
 - E. 130/90
- /83./ Чихний цочмог халдвартай хүүхдийн чихний өвдөлтийг намдаахаар юу зөвлөх вэ?
- A. Чихэнд фурациллинтэй спирт дусаах
 - B. Парацетамолыг 6 цагаар өвдөлт намдтал уулгах
 - C. Чихэнд тарвагны тос дусаах
 - D. Чихэнд хөхний сүү дусаах
 - E. Чихэнд пенициллин дусаах
- /84./ Гурвалсан мэдрэлийн өвдөлтийн үед тохиолдох боломжгүй шинжийг нэрлэнэ үү?
- A. Эрүү рүү дамжиж өвдөх
 - B. Хатгаж цоргиж, төөнөсөн маягтай хүчтэй өвдөх
 - C. Үе үе дахиж хөдлөх маягаар өвдөх
 - D. Дагз хүзүүний булчин чангарч өвдөх
 - E. Хацар, ам завьж рүү дамжиж өвдөх
- /85./ Төмрийн фолатыг хүнд цус багадалттай эмэгтэйд төрсний болон үр хөндүүлсний дараа яаж уулгах вэ?
- A. Өдөрт хагас шахмалыг уулгана
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш уулгана
 - C. Өдөрт 1 шахмалыг уулгана
 - D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уулгана
 - E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш уулгана

/86./ Улаанбурхэнтай 9 сартай хүүхдэд А аминдэмийн 100000 нэгжтэй, хөх капсулыг яаж өгөх вэ?

- A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг
- B. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь өг.
- C. 1 капсулыг яаралтай өг
- D. 2 капсулыг яаралтай өг.
- E. 3 капсулыг яаралтай өг

/87./ Гэдэсний хий гаргах гуурсыг сонгоно уу?

- A. Үзүүртээ төмөр хушуутай нарийн гуурс.
- B. Хатуу, нарийвтар гуурс.
- C. Хатуу, бүдүүвтэр гуурс.
- D. Хатуу, бүдүүн гуурс.
- E. Аль нь ч болно.

/88./ 3 настай уушгины хатгалгаатай хүүхдэд амоксациллины 250 мг шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1/2-ээр өдөрт 2 удаа 5 хоног
- B. 1 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
- C. 1 шахмалаар өдөрт 3 удаа 5 хоног
- D. 1/4 шахмалаар өдөрт 4 удаа 5 хоног
- E. 2 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног

/89./ 8 сартай 9 кг жинтэй, “Шингэн алдалттай суулгалт” гэж ангилагдсан хүүхдэд 4 цагийн турш ямар хэмжээний шингэн уулгах вэ?

- A. 200 мл
- B. 600-800 мл
- C. 1200-1400 мл
- D. 400 мл
- E. 2000 мл

/90./ Зүрхний булчинд үхжил үүссэнийг нотлоход хамгийн ач холбогдолтой арга нь аль вэ?

- A. СОЭ, цагаан эс тодорхойлох
- B. Цусанд ЛДГ тодорхойлох
- C. Цусанд шүлтлэг фосфатаза тодорхойлох
- D. Цусанд трансаминаз тодорхойлох
- E. Креатинин фосфакиназа тодорхойлох

/91./ Цэсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан юу вэ?

- A. Удамшил
- B. Сэтгэл санааны цочрол
- C. Цаг уурын өөрчлөлт
- D. Халдвар
- E. Витамины дутагдал

/92./ Заг хүйтнийг үүсгэгч гонококк эмэгтэйн шээс, бэлгийн замын хаана илүүтэй байрлах вэ?

- A. Давсаг
- B. Шээсний сүв
- C. Шээс дамжуулах цорго
- D. Умай
- E. Өндгөвч

/93./ Цусны глюкозын хэмжээг өлөн үед тодорхойлоход хэдэн цаг өлөн байх шаардлагатай вэ?

- A. 10-аас доошгүй цаг өлөн байх

- B. 2 цаг өлөн байх
- C. Юм идсэнээс 2 цагийн дараа
- D. 8-с доошгүй цаг өлөн байх
- E. 24 цаг өлөн байх

/94./ Зимницкийн сорилоор юу тодорхойлох вэ?

- A. 1 минутын диурез, бөөрний түүдгэнцэрийн шүүх ажиллагааг үзнэ.
- B. Шингэний ачаалал өгч бөөрний шингэрүүлэлтийн ажиллагааг үзнэ
- C. 1 мл шээсээр ялгарч байгаа дүрст элементийг тодорхойлно
- D. 24 цагийн шээсэнд дүрст элементийг тодорхойлно
- E. Бөөрний үйл ажиллагааг үзнэ

/95./ Леопольдийн 1-р аргаар юуг тодорхойлох вэ?

- A. Умайн ёроолын өндрийн түвшин
- B. Ургийн байрлал
- C. Түрүүлсэн хэсэг
- D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
- E. Ургийн жин

/96./ ДЭМБ/ОУГН-ийн ЗСӨ-ний эрсдлийн түвшинг тодорхойлох хүснэгтээр эрсдлийн түвшин хэд байвал өндөр эрсдэлтэй гэж тооцох вэ?

- A. 10
- B. < 20
- C. = 20
- D. > 20
- E. ≥ 20

/97./ Суулгаж байгаа хүүхдэд товлолын дагуу саагийн вакцин уулгах уу?

- A. Уулгах боловч тунг хийсэнд тооцохгүй, дараа сар нөхөж уулгана
- B. Дархлаа тогтохгүй учир уулгахгүй
- C. Уулгаад товлолын дагуу уусанд тооцно
- D. Уулгахгүй, товлолыг хойшлуулна
- E. Хэзээ ч уулгахгүй

/98./ А гепатитын нууц үе дунджаар хэд хоног үргэлжилдаг вэ?

- A. 10-15 хоног
- B. 10-45 хоног
- C. 45-90 хоног
- D. 50-180 хоног
- E. 2-4 сар

/99./ Зүрх судасны өвчний /ЗСӨ/ нийт эрсдэл гэж юу вэ?

- A. ирэх 10 жилд аминд халгүй, халтай ЗСӨ-өөр өвдөх магадлал
- B. өндөр эрсдэлтэй өвчтөн
- C. ирэх 5 жилд аминд халгүй, халтай ЗСӨ-өөр өвдөх магадлал
- D. Бай эрхтний гэмтэлтэй бол
- E. урьд нь ЗСӨ гэж оношлогдсон

/100./ Зүрхний шигдээсийн үед өвдөлт намдаах зорилгоор ямар эмийг хэрэглэх вэ?

- A. Морфин
- B. Валидол, нитроглицерин
- C. Седуксин
- D. Адерналин
- E. Рибокси

/101./ Атеросклероз үүсэх гол механизм юу вэ?

- A. Судас нарийсах
- B. Судасны сүв нарийсах
- C. Урсах цусны хэмжээ багасах
- D. Судасны ханын өөрчлөлт
- E. Холестрины хэмжээ ихсэх

/102./ “Чихний архаг халдвартай” гэж ангилсан, өөр ангилалгүй хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

- A. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- B. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ
- C. Чихээсээр чихийг хуурайшуулахыг зааж өгөөд 5 хоноод давтан үзүүлэхийг ба хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө.
- D. Антибиотик тарина
- E. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/103./ Жирэмснээс хамгаалахын тулд бэлгэвчийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?

- A. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна
- B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа бульчинд тарина.
- D. Биений юм ирсэн 3 дахь өдөр
- E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол

/104./ Оюуны хомсдолтой хүмүүст аль хандлага нь заавал хэрэгтэй вэ?

- A. Оюун ухааныг сайжруулах эмийн эмчилгээ
- B. Ад шоо үзэхгүй байх
- C. Тусгай сургуульд суралцуулах
- D. Амьдрах ур чадвар эзэмшүүлэх
- E. Гэр бүлийнхний асрамжинд байлгах

/105./ Төмрийн фолатыг хүнд цус багадаалттай жирэмсэнд яаж уулгах вэ?

- A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна.
- B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна.
- C. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
- D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уугаад, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна
- E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна

/106./ Улаанбурхантай 10 сартай хүүхдэд А аминдэмийн 200000 нэгжтэй, улаан капсулыг яаж өгөх вэ?

- A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг.
- B. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь зааж өг
- C. 1 капсулыг яаралтай өг.
- D. 2 капсулыг яаралтай өг
- E. 3 капсулыг яаралтай өг.

/107./ Бумбыг хэдэн хэмийн дулаантай өрөөнд тавьдаг вэ?

- A. 16-18 C
- B. 22-25 C
- C. 20-25 C
- D. 25-28 C
- E. 18-22 C

/108./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангиллыг бага эмч ямар шинжийг үндэслэн тавих вэ?

- A. Амьсгал олшрох, ханиалгах

- В. Цээж хонхолзох, ханиалгах
- С. Хяхтнаа амьгал, ханиалгах
- Д. Өндөр халуурах
- Е. Шуугиантай амьгал

/109./ Цус багадалттай хүүхдийг хэд хоноод давтан үзэх вэ?

- А. 2 хоноод
- В. 5 хоноод
- С. 10 хоноод
- Д. 14 хоноод
- Е. 30 хоноод

/110./ Цэрний түрхэцийн шинжилгээг хэдэн удаа авах вэ?

- А. Нэг удаа
- В. Хоёр удаа
- С. Сард дөрвөн удаа
- Д. Таван удаа
- Е. Гурван удаа

/111./ Артерийн гипертензийн үхэлд хүргэх шалтгаан аль вэ?

- А. Тархинд цус харвах
- В. Нүдний угт цус харвах
- С. Бөөрний дутагдал
- Д. Тархины цусан хангамжийн архаг дутагдал
- Е. Зүрхний дутагдал

/112./ Хөхлөг ургацын үрэвсэлтэй хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

А. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эмийн эхний тунг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

- В. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд гэрээр эмчилнэ
- С. Өвдөлт намдаах эм өгөөд гэрээр эмчилнэ
- Д. Чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.
- Е. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ

/113./ Багтраа өвчний цэр ямар онцлогтой вэ?

- А. Өтгөн ногоон цэр
- В. Салсархаг шингэн цэр
- С. Унжралдсан шиллэг цэр
- Д. Цусархаг цэр
- Е. Хөөсөрхөг цэр

/114./ Хеликобактераар үүсгэгдсэн гастритын гол эмчилгээ аль нь вэ?

- А. Нян устгах эмчилгээ
- В. Салстын нөхөн төлжилтийг сайжруулах
- С. Хөдөлгөөн зохицуулах
- Д. Ходоодны шүүрэл өдөөх эмчилгээ
- Е. Цес холбох

/115./ Тархмал хордлогот бахуутай хүний сувилгаанд аль нь хамаарах вэ?

- А. Халуун усанд оруулна.
- В. Хүйтэн усанд оруулна
- С. Гэрэлтүүлэг багатай өрөөнд байлгах
- Д. Гичтэй усанд оруулна
- Е. Хуурай халуун байранд байлгана

/116./ 10 сартай. амьсгал гаргалт шуугиантай байгаа хүүхдэд сальбутамолын 4 мг шахмалыг яаж өгөх вэ?

- A. 1\2-ээр өдөрт 3 удаа
- B. 1\2-ээр өдөрт 4 удаа
- C. 1\4-ээр өдөрт 3 удаа
- D. 1\4-ээр өдөрт 4 удаа
- E. 1 шахмалаар 1 удаа

/117./ Цөсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан юу вэ?

- A. Удамшил
- B. Сэтгэл санааны цочрол
- C. Цаг уурын өөрчлөлт
- D. Халдвар
- E. Витамины дутагдал

/118./ Туберкулины сорилыг хаана хийх вэ?

- A. Булчинд
- B. Судсанд
- C. Арьсан дор
- D. Арьсан дотор
- E. Арьсан дээр

/119./ Багтраа өвчний цэр ямар онцлогтой вэ?

- A. Өтгөн ногоон цэр
- B. Салсархаг шингэн цэр
- C. Унжралдсан, шиллэг цэр
- D. Цусархаг цэр
- E. Хөөсөрхөг цэр

/120./ Умайн ерөндөгийг хэдийд тавих нь тохиромжтой вэ?

- A. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
- C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа бульчинд тарина.
- D. Биений юм ирсэн 3 дахь өдөр
- E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол

/121./ Эрүүл нярай хүүхдийг төрснөөс хойш ямар хугацаанд амлуулах вэ?

- A. Дөнгөж төрмөгц
- B. Төрснөөс хойш 2 цагийн дараа
- C. Төрснөөс хойш 4 цагийн дараа
- D. Төрснөөс хойш 5 цагийн дараа
- E. Төрснөөс хойш 6 цагийн дараа

/122./ Төмрийн фолатыг хэвийн явцтай жирэмсэнд яаж уулгах вэ?

- A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна
- B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна
- C. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
- D. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна
- E. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уугаад, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна.

/123./ Улаанбурхэнтай 2 настай хүүхдэд А аминдэмийн 200000 нэгжтэй, улаан капсулыг яаж өгөх вэ?

- A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг
- B. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь өг
- C. 1 капсулыг яаралтай өг

D. 2 капсулыг яаралтай өг.

E. 3 капсулыг яаралтай өг.

/124./ Бөөрний шалтгаант цусны даралт ихсэх хам шинж хамгийн их илрэх өвчинг сонгоно уу?

A. Амилодоиз

B. Поликестоз

C. Архаг.гломерулонефрит

D. Архаг.пиелонефрит

E. Бөөрний сүрьеэ

/125./ Цус багадалттай 1,6 настай хүүхдэд төмрийн фолатыг ямар тунгаар, яаж өгөх вэ?

A. 1\4 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

B. 1\2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

C. 1 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

D. 1,5 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

E. 2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

/126./ Сүрьеэгийн халдвар тархах хамгийн гол зам юу вэ?

A. Арьсаар

B. Агаар дуслаар

C. Хоол боловсруулах замаар

D. Эхийн хэвлийгээр

E. Салстаар

/127./ Тархины судасны атеросклероз болоход эмнэлзүйд ямар шинж илрэх вэ

A. Цээжээр өвдөх

B. Толгой өвдөх

C. Дотор муухайрах

D. Хөл чинэрч өвдөх

E. Артерийн даралт ихсэх

/128./ 3 настай хүүхдийн чихнээс булаг гойжоод зовиургүй хагас жил болж байсан. Гэтэл өчигдөрөөс эхлээд хүүхэд халуурч, чих өвдөж байна гэж уйлагнасан. Үзлэгээр чихнээс булаг гарч байсан ба чихний ард хөндүүр хаван байгаагүй. Бусад шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

A. Халууралт. Чихний цочмог халдвар

B. Халууралт. Чихний архаг халдвар

C. Чихний өвчин байхгүй

D. Хөхлөг ургацын үрэвсэл.

E. Халууралт. Нойтон хульх

/129./ Хэрлэг төст үений үрэвслийн онцлог шинж юу вэ?

A. Эмгэг голчлон том үеийг хамарч хэрж өвдөнө

B. Хөлийн хурууны хурц үрэвсэл

C. Нурууны үе гэмтэж явж чадахгүй болно

D. 2 үе тэгш хэмтэй гэмтэж өглөөд бадайрч хөшнө

E. Өвдөгний үе хавдаж шөнөдөө маш хүчтэй өвдөнө

/130./ Шээсний ерөнхий шинжилгээнд хэвийн хувийн жин хэд байх вэ?

A. 1000-1005

B. 1005-1010

C. 1010-1015

D. 1015-1025

E. 1020 -1035

/131./ 38,5 хэмээс дээш хэлүүрч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яааж өгөх вэ?

- A. 1\4
- B. 1\2
- C. 1 бүтнээр
- D. 1.5
- E. 2 ш

/132./ Уушгины үрэвслийн үед халдварын эсрэг ямар эмийг сонгох вэ?

- A. Антибиотек
- B. Антиоксидант
- C. Антигистамин
- D. Хордлогын эсрэг эмчилгээ
- E. Дархлаа дэмжих эмчилгээ

/133./ Атеросклерозын үүсэл хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү

- A. Амьтны гаралтай өөх тос хэрэглэх
- B. Давс их хэрэглэх
- C. Эрс тэс уур амьсгал
- D. Байгаль газар зүйн онцлог
- E. Бодисын солилцоо удаан явагддаг

/134./ Элэг цэсийг хэт авиан шинжилгээгээр шинжлэхэд өвчтөнд ямар бэлтгэл хийх вэ?

- A. Өлөн байлгах
- B. Цэвэрлэх бургуй тавих
- C. Давсаг шээстэй байх
- D. Ходоод угаах
- E. Урьд оройноос хоол сойх

/135./ Бага эмч сүрьеэг оношлох шинжилгээний гол арга юу вэ?

- A. Уушгины гэрлийн шинжилгээ
- B. Мантугийн сорил
- C. Цусны ерөнхий шинжилгээ
- D. Цэрний шинжилгээ
- E. Бронхоскопи

/136./ Зүрхний шигдээсийг эрт илрүүлэх биохимийн маркер аль нь вэ?

- A. АСАТ
- B. АЛАТ
- C. КФК
- D. Холестрин
- E. Тропонин

/137./ Зүрхний ишеми өвчинг үүсгэх гол шалтгаан юу вэ?

- A. Удамшил
- B. Халдвар
- C. Титэм судас хатуурах
- D. Архаг халдварын голомт
- E. Хөгшрөлт

/138./ Умайн салстын архаг үрэвслийн үед илрэх эмнэлзүйн гол шинж тэмдэг юу вэ?

- A. Халуурах
- B. Сарын тэмдэг хаагдах
- C. Хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх
- D. Сарын тэмдгийн мөчлөг алдагдах

Е. Цусархаг шингэн байнага гарах

/139./ Альгодисменорея гэж ямар эмгэгийг хэлэх вэ?

- А. Сарын тэмдэг цөөн хомс ирэх
- В. Сарын тэмдэг өвдөлттэй ирэх
- С. Сарын тэмдэг мөчлөггүйгээр их ирэх
- Д. Сарын тэмдэг багаар удаан үргэлжлэх
- Е. Сарын тэмдгийн мөчлөг хэвийн боловч гарах цусны хэмжээ элбэг

/140./ ОНБТБ-ийг сум, өрхийн эмч хүүхдийн хэдэн сартайд олгох вэ?

- А. 6 сартайд 60 ширхэгийг олгоно
- В. 12 сартайд 60 ширхэгийг олгоно
- С. 18 сартайд 60 ширхэгийг олгоно
- Д. 23 сартайд 60 ширхэгийг олгоно
- Е. 24 сартайд 60 ширхэгийг олгоно

/141./ Ходоодны А хэлбэрийн архаг үрэвслийн үед доорх зовиуруудаас аль нь илрэхгүй вэ?

- А. Гэдэс дүүрч хоржигнох
- В. Суулгах
- С. Турах
- Д. Цээж хорсох
- Е. Толгой эргэж нүд бүрэлзэх

/142./ “Рахитгүй” гэж ангилагдсан хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн шахмалаас ямар тунгаар, хэдийд өгөх вэ?

- А. Нэг удаа 1 шахмал уулгана
- В. Даваа гариг бүрт 1 удаа 1 шахмалыг 1 сар өгнө
- С. 6,7,8,9-р саруудад урьдчилан сэргийлэх тунг уулгахгүй. Бусад саруудад 14 хоногтойгоос эхлээд 1 шахмалыг 2 нас хүртэл сар бүр уулгана.
- Д. Рахитгүй тул Д аминдэм уулгахгүй
- Е. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа 1 шахмалаар, нийт 7 удаа өгнө

/143./ Гуурсан хоолойн салст бүрхэвчинд байрлах сормууст эс ямар үүрэгтэй вэ?

- А. Цэвэрлэх шүүх
- В. Липопротейд ялгаруулах
- С. Дулаан үүсгэх
- Д. Шүүрэл ялгаруулах
- Е. Нөхөн төлжилт хийх

/144./ 4 настай хүүхдийн чихнээс ногоон булаг гараад сар болж байна. Чих өвдөж байна гэж хэлдэггүй, халуурдаггүй, зовиур шаналгаа илэрдэггүй боловч ээж нь үзүүлэхээр авчирсан. Үзлэгээр өвдөлт ба хөхлөг ургацын үрэвслийн шинжгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- А. Чихний цочмог халдвар
- В. Чихний архаг халдвар
- С. Чихний өвчин байхгүй
- Д. Хөхлөг ургацын үрэвсэл
- Е. Нойтон хульх

/145./ Зүрхний бахын үед ямар хүндрэл гарах вэ?

- А. Зүрхний шигдээс
- В. Зүрхний гаралтай шок
- С. Зүрхний багтраа
- Д. Тархинд цус харвах
- Е. Таталт өгөх

/146./ Зүрхний шигдээсээр өвчилсөн хүмүүст аспирин уулгадаг. Аспирин ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?

- A. Венийн судсыг тэлэх
- B. Тромбин үүсэх үйл явцыг саатуулах
- C. Тромбоцитийн агрегацийг багасгах
- D. Бүлэн уусгах
- E. Зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хэрэгцээг бууруулах

/147./ 38,5 хэмээс дээш халуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1\4
- B. 1\2
- C. 1 бүтнээр
- D. 1.5
- E. 2 ш-ээр

/148./ Ходоодны В хэлбэрийн архаг үрэвслийн үндсэн шалтгаан юу вэ?

- A. Удамшил
- B. Сэтгэл санааны цочрол
- C. Хелико бактер
- D. Хоолны дэглэм алдагдах
- E. Эмийг буруу хэрэглэх

/149./ Хүүхдэд цээж хонхолзох шинж илэрч байвал бага эмч хэрхэн ангилах вэ?

- A. Ханиад шуухнаа
- B. Уушгины хүнд хатгалгаа
- C. Уушгины хатгалгаа
- D. Багтраа
- E. Ларингит

/150./ Бөөрний гаралтай хавангийн онцлог юу вэ?

- A. Хүйтэн, хатуу, дарахад хонхойно
- B. Улаавтар, хатуу, бүлээн
- C. Цайвар, зөөлөн, дарахад хонхойно
- D. Хатуувтар, хөхөвтөр, дарахад хонхойно.
- E. Зөөлөн, шаравтар, бүлээн

/151./ Туберкулины сорилын хариу урвалыг хэзээ хэмжиж тодорхойлох вэ?

- A. 72 цагийн дараа
- B. 48 цагийн дараа
- C. 24 цагийн дараа
- D. 2-3 долоо хоногийн дараа
- E. Сорилыг даруй уншина

/152./ Гуурсан хоолойн цочмог үрэвсэл үүсэхэд шууд нөлөөлдөг хүчин зүйл юу вэ?

- A. Пневмококк
- B. Тамхины утаа
- C. Агаарын бохирдол
- D. Амьсгалын дээд замын вирусийн халдвар
- E. Химийн бодис

/153./ Зүрхний шигдээсийн үед үзүүлэх анхны тусламжийн зарчим аль нь вэ?

- A. Мэс засал
- B. CPR
- C. Хүчилтөрөгч өгөх

- D. MONA зарчим
- E. Өвдөлт намдаах

/154./ Сарын тэмдэгийн мөчлөгийн хугацааг яаж тогтоох вэ?

- A. Сарын тэмдэг ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэгийн анхны өдөр хүртэл
- B. Сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс дараагийн сарын тэмдэгийн анхны өдөр хүртэл
- C. Сарын тэмдэг ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэг дууссан өдрийг хүртэл
- D. Сарын эхний 5 хоног
- E. Сарын сүүлийн 5 хоног

/155./ Цээжний гэмтлийн үед үзүүлэх эмчилгээ, сувилгааг сонгоно уу?

- A. Эмчлүүлэгчийг тайван байлгаж, дулаацуулна
- B. Өвдөлт намдаах эм хэрэглэнэ
- C. Зүрхний үйл ажиллагааг дэмжинэ
- D. Цээжийг өндөрлөн, хүчилтөрөгч амьсгалуулна
- E. Хавирганы завсраар новокайны хориг хийнэ

/156./ Долгорын хэвлийн дээд хэсгээр өвдөж, маргааш өглөө хэвлийн ЭХО шинжилгээ хийлгэх болов. Сувилагч ямар зөвлөгөө өгөх вэ?

- A. Ходоод хоосон байх шаардлагатай
- B. Шинжилгээний дараа ямар нэг эмчилгээ хийх шаардлага гарч магадгүй
- C. Бага зэрэг юм идэж болно
- D. Өглөө шинжилгээнд өлөн ирээрэй
- E. Их юм ууж идэхгүй ирээрэй

/157./ 6-12 сартай хөхөө хөхдөг хүүхдэд нэмэгдэл хоолнуудад дасгасны дараа өдөрт хэдэн удаа нэмэлт хоол өгөх вэ?

- A. 1 удаа
- B. 2 удаа
- C. 3 удаа
- D. 4 удаа
- E. 5 удаа

/158./ Бүдүүн гэдэсний үүргийг нэрлэнэ үү?

- A. Уургийн задрал явагдана
- B. Усыг шимэгдүүлнэ
- C. Нянгийн нөлөөгөөр ислэг задарч дулаан үүснэ
- D. Өтгөнийг ялгаруулна
- E. Бүгд

/159./ “Рахиттай” гэж ангилагдсан хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн шахмалаас ямар тунгаар өгөх вэ?

- A. Сард нэг удаа 1 шахмалыг , 2 нас хүртэл
- B. Даваа гариг бүрт 1 удаа 1 шахмалыг 1 сар өгнө
- C. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа 1 шахмалаар , нийт 7 удаа өгнө
- D. Сард нэг удаа 1 шахмалыг 1 жил уулгана
- E. Сард нэг удаа 1 шахмалыг 2 жил уулгана

/160./ Манас таталтын урьдлын хүнд хэлбэрийн үед ямар шинжүүд илэрдэг вэ?

1. Хоёр хэмжилтэнд сулралын даралт 90 МУБӨ, толгой хүчтэй өвдөх, нүд бүрэлзэх, аюулхайд өвдөх шинжүүд илрэх
2. Хавагнана
3. Сулралын даралт 110 мм МУБӨ ба түүнээс их мөн шээсэнд уураг 3+
4. Шээсэнд уураг 2+ илэрнэ
5. Шээсэнд лейкоцит ихээр илрэх

/161./ Сэтгэл түгших үед өвчтөнд илэрч болох шинжүүд:

1. Зүрх дэлсэх, судасны цохилд олшрох, артерийн даралт ихсэх
2. Амьсгал олшрох, амьсгаа давчдах, цээжин дээр хүнд юм дарах мэт санагдах
3. Ходоод орчим өвдөх, агших нь мэдэгдэх, юм залгихад түвэгтэй мэт санагдах
4. Шээс ойр ойрхон хүрэх
5. Нойр хульжих

/162./ Зүрхний дутагдлаас үүсэж буй амьсгаадалтын үед ямар эмчилгээ чухал вэ?

1. Дигоксин эсвэл коргликон
2. Панангин эсвэл калийн хлорид
3. Фуросемид эсвэл диакарб
4. Эуфиллин
5. Антибиотик

/163./ Шээлгүүр тавих зорилгыг тодорхойлно уу?

1. Давсаг угаах
2. Давсган дахь шээсийг авах
3. Давсганд эмийн бодис хийх
4. Давсаг дурандахын өмнө
5. Давсганд мэс засал хийхийн өмнө

/164./ Оюуны хомсдолтой өвчтөний гэр бүлийнхэнд өрхийн эмчийн зүгээс өгөх зөвлөмж:

1. Өөрийгөө арчлах дасгал сургуулилтыг байнга хийлгэж байх
2. Бусдыг хайрлах, өрөвдөх харилцааг эзэмших чадвартай тул байнга дэмжиж байх
3. Өвчтөний ололт амжилт, зүтгэлийг байнга урамшуулж байх
4. Оюуны хомсдолтой хүүхдийг байнга хайр халамжаар хүмүүжүүлэх
5. Оюуны хомсдлыг эмчлэх эмчилгээ байхгүй боловч амьдрах ур чадварыг эзэмшүүлэх нь

түүнд ба гэр бүлд тустайг ойлгуулах

/165./ Хүнд тураалтай” гэж ангилагдсан хүүхдэд ямар шинжүүд илрэх вэ?

1. Хараажийн хүнд тураалын шинжүүд
2. Уураг дутагдлаас хоёр хөлөнд хавантай байх
3. Биеийн жин маш бага байх
4. Дагзны үс халцарсан
5. Булчин суларсан

/166./ Умайн ерөндөгийн ашигтай тал юу вэ?

1. Удаан хугацаагаар жирэмслэлтээс хамгаална. Цэвэрших хүртэл хэрэглэж болно.
2. Төрсний болон үр хөндүүлсний дараа шууд тавьж болно
3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй
4. Бэлгийн замын халдвараас сэргийлнэ
5. Умайн цус алдалтыг багасгана

/167./ Гэдэс түгжрэх нь хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хэвлий дүүрч, цардайж өвдөх
2. Өтгөн, хийгээ гаргаж чадахгүй болох
3. Хэвлийн тойм зурганд Клойбэрийн аяганууд илрэх
4. Хараар баах
5. Цусанд диастаза ихсэх.

/168./ Жирэмсний хожуу үеийн хордлогын шинж илрэхэд эх яагад эмчид даруй үзүүлэх ёстой вэ?

1. Эхэс хавагнах, ураг бүтэх магадлал ихтэй
2. Эх манас таталтаар хүндрэх магадлал ихтэй

3. Эх амь насаа алдах аюултай
4. Төрөлхийн гажигтай хүүхэд төрөх магадлал өндөр
5. Хөлний хаван насан туршдаа тогтох магадлал өндөр

/169./ Ужиг суулгалттай хүүхдэд өгөх хооллолтын зөвлөгөө

1. Насанд нь тохирсон хоолыг өгнө, хүссэн цагт нь хөхүүлэх
2. Шинэхэн бүрсэн тараг шүүж уулгах
3. Сүү уудаг бол түүнийг нь хасах эсвэл цагаан будааны шүүсээр 2 дахин шингэлэх
4. Хоолыг сойх
5. Нэмэлт хоолыг нь хасаад зөвхөн үнээний сүү уулгах.

/170./ Ампициллин, Гентомицин зэрэг 2 антибиотикийг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?

1. Маш хүнд халууралт өвчнүүд
2. Шээсний дээд замын өвчин эсвэл уушгины хатгаа
3. Умайн болон ургийн халдвар
4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан
5. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт

/171./ Жирэмсэн эхэд хорт зуршилын хор уршигын талаар юуг зөвлөх вэ?

1. Жирэмсэн эх тамхи татах нь жин багатай, төрөлхийн бүтэлттэй хүүхэд төрүүлэх магадлал их байдаг
2. Тамхичин эхээс төрсөн хүүхэд гэнэт нас барах аюултай
3. Согтууруулах ундаа хэрэглэж болохгүй, учир нь оюуны хомсдолтой хүүхэд төрөх магадлал өндөр байдаг.
4. Тамхи татах нь төрөх үеийн сулрал үүсгэдэг
5. Архи уух нь төрөх үед цус алдалт үүсгэдэг

/172./ Эмч, эх баригч, сувилагч нар төрсний дараах хяналтаар юуг үнэлж, зөвлөх вэ?

1. Хүүхдээ хөхөөр хооллож байгаа эсэх, хүүхэд эрүүл өсөж байгаа эсэхийг хянах
2. Эх Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТБ) болон А аминдэм ууж байгаа эсэхийг хянах
3. Нярайн хоол, асаргааны талаар зөвлөгөө өгөх
4. Нярайн вакцинд хамрагдсан байдлыг хянах
5. Нийгмийн халамжийн тусламжинд хамрагдсан эсэх

/173./ Хүүхдийн түвэнхийн үрэвсэл, нарийсал ямар шинжүүдээр илэрдэг вэ?

1. Хяхтнаа амьсгал
2. Хоолой сөөх
3. Хуцуулах ханад
4. Шуугиант амьсгал
5. Хөхүүлэх ханиад

/174./ Эх барихын тусгайлсан асуумжаар дараах зүйлүүдийг тодруулна.

1. Жирэмслэлт, төрөлтийн тоо
2. Түрүүчийн жирэмслэлт, төрөлтийн явц, хүндрэл
3. Сүүлчийн сарын тэмдэг
4. Төрүүлсэн хүүхдийн жин, амьд эсэх, гарсан хүндрэл
5. Эх барихын ба эмэгтэйчүүдийн ямар нэг мэс ажилбар хийлгэж байсан эсэх

/175./ ЭМСайдын тушаалаар 12 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр юу хийх ёстой вэ?

1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
2. Эх барихын тусгайлан үзлэг хийх

3. Нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх
4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тогтоох
5. Ургийн зүрхний цохилтыг сонсох

/176./ ХӨЦМ-ийн дагуу “Ханиад шуухнаа” гэдэг ангилалтай хүүхдийг бага эмч гэрээр эмчлэхдээ ямар шинж илэрвэл яаралтай ирж үзүүлэхийг зөвлөх вэ?

1. Уух буюу хөхөндөө муудах
2. Өвчин хүндрэх
3. Халуурах
4. Амьсгал олшрох
5. Амьсгал саадтай болох

/177./ Манас таталтын урьдал үедийн шинжүүд илэрсэн жирэмсэн эхэд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Ачааллаа багасгахыг зөвлөнө
2. Долоо хоногийн дараа давтан үзүүлэхийг зөвлөнө
3. Долоо хоногийн дараа даралт их байвал эмнэлэгт хэвтүүлэхийг сануулна
4. Эмнэлэгт хэвтүүлнэ
5. Магнийн сульфат хийнэ

/178./ Сэтгэл түгшилтийг ихэсгэдэг органик шалтгаанууд:

1. Дотор муухайрах буюу бөөлжих
2. Уураг тархины эмгэгүүд (тархины үрэвсэл, гэмтэл, хавдар)
3. Ухаан балартах
4. Амьсгалын дутагдалд хүргэдэг амьсгалын тогтолцооны эмгэгүүд
5. Хорт хавдарын гаралтай хүчтэй өвдөлт

/179./ Амьсгалын тогтолцооны ямар эмгэгийн үед амьсгаадах шинж илэрдэг вэ?

1. Гуурсан хоолойн бөглөрөлт үрэвсэл, уушгины цочмог хатгалгаа
2. Түвэнх хоолойн үрэвсэл, бачуурал. Багтраа
3. Уушгины архаг үрэвсэл буюу пневмосклероз. Уушги тоосжих өвчин буюу пневмокониоз
4. Уушгины ба гялтангийн хавдар
5. Уушгины шүүдэст плеврит, пневмоторокс

/180./ Цэвэрлэх бургуй ямар механизмаар үйлчилдэг вэ?

1. Гэдэсний ханын мэдрэлийн төгсгөлийг цочрооно.
2. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг нэмэгдүүлнэ.
3. Өтгөнийг гадагшлуулах үйлчилгээ үзүүлнэ.
4. Гэдэсний ханы мэдрэлийн төгсгөлийн мэдрэх чадварыг бууруулна.
5. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг багасгана.

/181./ Хараажийн хүнд тураалтай хүүхдэд ямар шинжүүд илрэх вэ?

1. Мөчид нарийсах
2. Хавирга хэрзийх
3. Илүүдэл өмөдний шинж
4. Хөлрөмтгий
5. Дагзны үс халцарсан

/182./ Цээжээр өвдөх нь зүрхний бах, шигдээсийн шалтгаантай болохыг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Өдвөлт зүүн гар, мөр рүү дамжих
2. Цээж давчин, агаар дутагдах, айдас төрөх
3. Зүрхний хэмнэл алдагдах, цусны даралт хэлбэлзэх
4. Өдвөлт баруун гар, мөр рүү дамжих
5. Гүн амьсгалах, ханиах үед өвдөлт ихсэх

/183./ Депо-провераг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?

1. Жирэмсэн
2. Зүрхний цус хомсдох эмгэг, цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй.
3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
4. Бэлгийн замын халдвар
5. Хөхүүл

/184./ В вируст гепатитаас урьдчилан сэргийлэх зорилгоор бага эмч ямар арга хэмжээнүүдийг авсан байх ёстой вэ?

1. Нярайд 24-48 цагийн дотор, мөн 2,8 сартай хүүхдийг В гепатитын эсрэг өвөрмөц дархлаажуулалтанд хамруулна
2. Өвчлөгсдийг эрт илрүүлэх
3. Доноруудыг шинжлэх
4. Нэг удаагийн тариур, багаж хэрэгсэл ашиглах
5. Бээлий, хөдөлмөр хамгааллын хувцас ашиглах

/185./ Умайн гадуурх жирэмслэлт хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хэвлийн доод хэсгээр өвдөнө
2. Үтрээнээс хар хүрэн цусархаг ялгадас гарна
3. Үтрээний арын хүнхрээний хатгалт хийхэд цус сорогдоно
4. Цустай баана
5. Ургийн хэсгүүд тэмтрэгдэнэ

/186./ Гич тавих талбайг олно уу?

1. Цээжний араар
2. Эрээн булчинд
3. Зүрх орчим
4. Хүзүүний арын хэсэгт
5. Хүйсэн дээр

/187./ Жирэмсний хожуу үеийн хордлого ямар шинжээр илэрдэг тухай эхэд ямар мэдээллийг өгөх вэ?

1. Жирэмсний жин долоо хоногт 350-400 граас илүү ихээр нэмэгдэх
2. 2 хөл, биеэр хавагнах
3. Шээсний гарц багасах
4. Толгой өвдөх, артерийн даралт ихсэх
5. Шээсэнд уураг ялгарах

/188./ “Шингэн алдалтгүй, ужиг суулгалт” гэж ангилагдсан 2 настай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Шингэн алдалтаас сэргийлж А төлөвлөгөөний дагуу эмчилнэ
2. Зөв хооллох талаар эхэд зөвлөнө
3. Мультивитамин 14 хоног уулгана
4. Хэзээ яаралтай ирэхийг зөвлөнө
5. 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө

/189./ Цэвэрлэх бургуйг тавихдаа үйлчлүүлэгчийг баруун хажуугаар нь хэвтүүлдэг яагаад гэвэл нэг удаад 5-6 литр крантны усаар тавьдаг учир дээрхи байрлал тохиромжтой байдаг.

/190./ Сорил тарилгыг харшлыг илрүүлэх зорилгоор тавьдаг учир бугалганы 1/3 орчмын талбайг сонгодог яагаад гэвэл зарим тохиолдолд халдвараас сэргийлэх зорилгоор тавьдаг.

/191./ Биеийн халуун өглөө 9-11 цаг, оройн 16-18 цагийн хооронд багасаж , хэвийн байдалдаа ордог. Ердийн эрүүл насанд хүрсэн хүний халуун 37-38 хэм байдаг ба хүүхдийнх 35.5-36.5 байдаг.

/192./ Асаргаа сувилгааны үндсэн зарчимд орчин хоол, хувцаслалт нь чухал яагаад гэвэл, эмчлүүлэгчийн сэтгэлзүйг дэмждэг учир хүн бүрт энэ үйл ажиллагааг төлөвлөдөг

/193./ Эмийн бодисыг тарилгаар хэрэглэхийн өмнө шалгахдаа эмийн түүвэртэй тулгах, тариурт соруулахын өмнө шалгах, тарилгыг хийсний дараа шалгах орно.

/194./ Арьс хэвийн бус цайж цонхийх нь хүнд хэлбэрийн цус багадалтын шинж тиймээс цус сэлбэх шаардлагатай учир зөвхөн цусны бүлгийг шалгасан байхад хангалттай

/195./ Хүчилтөрөгчийн майхан нь урсгалын хурдыг багаар шаарддаг учир урсгал саадгүй эсэхийг шалгах шаардлагагүй ба өртөг бага шаарддаг.

/196./ 90хэмийн өнцгөөр булчингийн нэхмэл эдэд хатгана. Бүлүүрээ хойш татаж, судас таарсан эсэхийг шалгана. Хэрэв судас таарсан бол зүү тариурыг сугалан өөр газарт хийнэ.

/197./ Эмчилгээний зорилгоор эмийн бодисыг арьсан дор оруулдаг.Зүү тариураар 45-60,90хэмийн өнцгөөр хатгаж эмийн бодисыг хийнэ.Зөв таригдсан бол арьсан дээр нимбэгний гадарга шигцагаан цэврүү үүснэ.

/198./ Эмийн бодисыг хэрэглэхдээ тухайн эмийн нэр, тун хэмжээг сайтар шалгах ба эмийн бодисын үйлдвэрлэсэн хугацаа чухал биш.

/199./ Ревматоидный артрит гэсэн оношийг тавих илүүтэй шинж тэмдгийг сонгоно уу?

- А. Эмгэг процесс голчлон том үеүдийг хамрах ба хэрсэн үений өвдөлт илрэх
- В. Тогтвортой үений өвдөлт зүрхний өөрчлөлт
- С. Хөлийн эрхий хурууны үений хурц үрэвсэл
- Д. Үе 2 талдаа ижил гэмтэж өглөөний хөшингө илрэх
- Е. Нурууны үе идэгдэж,хүйтэн буглаа үүсэх

/200./ Хүүхэд нярайлах хугацааг яаж тогтоох вэ?

- А. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс 3 сарыг хасч, 15 хоног нэмнэ.
- В. Сүүлийн сарын тэмдэг ирсэн эцсийн өдрөөс 3 сарыг хасч, 15 хоног нэмнэ.
- С. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс 3 сарыг хасч, 7 хоног нэмнэ
- Д. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдөр дээр 9 сарыг нэмнэ
- Е. Сүүлийн сарын тэмдэг ирсэн эцсийн өдөр дээр 10 сарыг нэмнэ.